

*Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хорооны саналаар хийсэн
аудитын тайлан*

**Оюу толгойн орд газрын нөөцийг тогтоож баталгаажуулсан болон
“Энержи ресурс” ХХК-д нүүрсний орд ашиглах талбай,
тусгай зөвшөөрөл олгосон байдал**



2012 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Захирал Д. Ганбилэг

Аудитын менежер
Х.Баярмаа

Ахлах аудитор
Ц.Гэрэл
С.Сэрчхорол

Ахлах шинжээч
У.Баярмаа
Л.Эрдэнэчулуун

Шинжээч Ц.Цолмон
Ш.Энхтайван
Б.Болормаа
Д.Баттулга
Д.Цэрэндорж
Т.Батзориг
Ж.Ганчимэг
С.Пүрэвсүрэн
О.Баттулга
Л.Батжаргал

2012 оны 3 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын
Веб сайт-аас үзнэ үү.

www.mnao.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160
Монгол улс

Товчилсон үгийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3
Бүлэг 1 Оюу толгойн орд газрын нөөцийг баталгаажуулсан талаар	
Ерөнхий мэдээлэл.....	4
Оюу толгойн орд газрын нөөцийг тогтоох эрх зүйн орчны талаар.....	5
Оюу толгойн орд газрын нөөцийг тогтоож баталгаажуулсан талаар.....	6
Нөөц нэмэгдсэн эсэх талаар.....	7
Оюу толгойн орд газрын нөөцийн өөрчлөлтөд хэрхэн хяналт тавьж буй талаар.....	8
Бүлэг 2 Энержи ресурс ХХК-д ашиглалтын талбай, тусгай зөвшөөрөл олгосон талаар	
Ерөнхий мэдээлэл	10
Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон тухай.....	10
Дагаж мөрдөх журмын тухай хуулийн талаар.....	11
Тусгай зөвшөөрлийг шилжүүлж авсан талаар.....	11
Эрдэнэс-МГЛ ХХК болон Энержи ресурс ХХК-ийн хоорондын хамтын ажиллагааны талаар.....	12
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн талаар.....	12
Тусгай зөвшөөрлийн төлбөрийн талаар.....	13
Дүгнэлт.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГ	Засгийн газар
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭБЭХС	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
ҮХС	Үйлдвэр, худалдааны сайд
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
АМГ	Ашигт малтмалын газар
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
ГУУКА	Геологи, уул уурхайн кадастрын алба
ЭХУУГЯ	Эрчим хүч, уул уурхай, геологийн яам
ШУТЗ	Шинжлэх ухаан, технологийн зөвлөл
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ЗБН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны саналыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Оюу толгойн орд газрын нөөцийн хэмжээ, “Энержи ресурс” ХХК-д нүүрсний орд ашиглах талбай, тусгай зөвшөөрөл олгосон байдлыг шалгаж дүгнэлт гарган УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороонд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Оюу толгойн орд газрын нөөцийг хууль, тогтоомж, дүрэм, зааврын дагуу тогтоож, баталгаажуулсан эсэх
- Энержи ресурс ХХК-д нүүрсний орд ашиглах талбай болон тусгай зөвшөөрлийг хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу олгосон эсэх

Хамрах хүрээ:

Монгол Улсын Засгийн газар, ЭБЭХЯ, БОАЖЯ, АМГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, “Оюу толгой” ХХК, “Энержи ресурс” ХХК болон холбогдох бусад байгууллагуудын тайлан, мэдээлэл, бусад баримт материалд тулгуурлан аудит хийв.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах;
- Хамрагдсан байгууллагуудын ажлын тайлан, төслийн сонгон шалгаруулалтын явц, тайлагнал, цуглуулсан мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын багийн мэргэжлийн шинжээчээр ШУТИС-ийн доктор, зөвлөх инженер Д.Дондов, Уулын ашиглалтын зөвлөх инженер Г.Энхбаяр нар ажиллалаа.

Ерөнхий мэдээлэл

1.1. Оюу толгойн зэс, алтны орд нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Баруун Өмнөд Оюу, Төв Оюу, Завсрын гэсэн хэсгүүдэд Оюутын хэсгүүд болон Хюго Дамметтын гэсэн үндсэн 2 орд (хэсэг)-оос тогтоно. Оюутын хэсгийг ил аргаар, Хюго Дамметтын хэсэгт хүдрийг далд аргаар ашиглах ерөнхий төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Зураг 1. Оюу толгойн ордын ерөнхий зураг



1.2. Уг орд нь хүрэл зэвсгийн үеэс мэдэгдэж байсан нь эртний малталтууд, тэндээс олдсон зэвсгүүд, бусад ордын илрэлүүдэд ажиглагддаг бөгөөд 1970-аад оноос дараах байдлаар судлагджээ¹. Үүнд:

- 1958 онд ЗХУ-ын геологич Ю.Я.Петрович нар Өмнөд Оюу толгой дахь эртний малталтуудын орчмоос сорьц авч шинжлүүлэн 1-3%-ийн зэсийн агуулга илрүүлснээс гадна, хоёрдогч баяжилтын бүс үүссэн байх боломжтойг тогтоосон,
- 1972 онд Н.А.Маринов, Р.А.Хасин нарын редакторлан хэвлүүлсэн Монгол орны ашигт малтмалын зураг дээр уг ордыг Бор овооны зэсийн илрэл гэж,
- 1983 онд геологич Д.Гарамжав Ханбогдын шүлтлэг боржингийн массивын структурын зураг хийж байх үед одооны Өмнөд Оюу толгойг судлан зэсийн исэлдсэн хүдэр байгааг,
- 1995 онд Э.Бүрэнхүү нар 1:200000 масштабтай геологийн зураг хийж байхдаа Төв Оюу Толгой орчмоос авсан чулуулгийн сорьцод молибдены өндөр агуулгатайг,
- 1996 оны 9 дүгээр сард Магма компанийн геологич Сергей Диаковоор удирдуулсан хайгуулын анги Өмнөд Монголын бүсэд зэс молибдены илрэлүүдэд үнэлгээ өгөх үедээ Төв Оюу Толгойн орчны чулуулгийн гаршуудыг судалсны үндсэн дээр доороо халькозины баяжилтын бүс бүхий порфирийн систем байгаа болохыг тус тус тэмдэглэжээ. Үүнээс үндэслэн

¹ Үндэсний аудитын газраас 2007 онд Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын ажлын баримтын 1 дүгээр боть 42 дугаар хуудас

хайгуул судалгааны лиценз авах өргөдөл гаргаж энэ ордод хайгуулын ажил хийх эхлэл тавигджээ.

- 1996 оны эцсээр “Би Эйч Пи Минералс” компани “Магма” компанийг худалдан авч 1997 оны 2 дугаар сарын 17-нд Оюу толгойд 1120 км² талбайд хайгуул хийх лиценз авч, 4 сараас Оюу толгойн орчимд топо зураг 56 км², соронзон зураглал 56 км², албадмал туйлшралын 12 км² судалгаа хийж, 12 км хэмжээтэй соронзон орны болон туйлшралын гажил илрүүлж, улмаар хайгуулын үр дүнгээр Төв Оюу толгойн орд дээр гипергений халькозины хоёрдогч баяжилтын бүс Өмнөд Оюу толгойн орд дээр илэрсэн зэс-алтны гажил бүхий кварц-магнетитын штокверкуудтай холбоотой үүссэн байж болох тул тэнд алмазан өрөмдлөг хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна.
- 1997 оны 9 дүгээр сард “Би Эйч Пи минералс” компани лицензийн талбайд илэрсэн гажлыг шалгах анхны 1000 тууш м алмазан өрөмдлөгийг 6 цэгт хийснээс 5 цооногт зэсийн хүдэр, 1 цооногт пиритийн эрдэсжилт илрүүлснээр Төв бүсэд хоёрдогч баяжилт, Баруун өмнөд бүсэд 2-3 хүдэржилтийн голомт байгааг нээсэн байна.
- 1998 онд мөн дээрх талбайд хойш 1.5 км, баруун тийш 1 км сунган соронзон зураглал, албадмал туйлшралын судалгаа, цахилгаан соронзон хэмжилт хийжээ.
- 1997-1998 оны хайгуулын ажлын үр дүнд Оюу толгой ордод хийсэн геологийн зураглал болон геофизикийн судалгаагаар Оюу толгойн талбайн геологийн тогтоцын онцлог, Өмнөд, Төв болон Хойт оюу толгойн хэсгүүд, тэдгээрийн хүдрийн төрлийг тодорхойлсон.
- 2002 оны 4 дүгээр сарын 19-нд ГУУКА-ны даргын 254 дүгээр шийдвэрээр “Би Эйч Пи минералс” ХХК-иас Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК-д хайгуулын лицензийг шилжүүлжээ.

Оюу толгойн орд газрын нөөцийг тогтоох эрх зүйн орчны талаар

- 1.3. Монгол Улсын уул уурхайн салбарт ашигт малтмалын орд газрын нөөцийг тогтоож, баталгаажуулах эрх зүйн орчныг Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох дүрэм журмаар тогтоожээ.
- 1.4. Ашигт малтмалын тухай хуулийн (2006 оны) 10.1.1, 10.1.8, 10.1.9²-д зааснаар ЭБЭХЯ нь ашигт малтмал, геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх төрийн бодлогыг боловсруулж, биелэлтийг хангуулах болон Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайланд дүгнэлт, зөвлөмж өгөх үүрэг бүхий ЭБМЗ-ийг байгуулж, дүрмийг нь батлах чиг үүрэгтэй бол мөн хуулийн 11.1.2, 11.1.5, 11.1.6³-д зааснаар АМГ нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэлбэршилтийн судалгаа хийж, эрдэс баялгийн нөөцөд үнэлгээ өгөх, үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлж, түүнийг баяжуулах, хайгуулын ажлын явцад хяналт тавих чиг үүрэгтэй байна.

² 10.1.1. геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, биелэлтийг хангах

10.1.8. стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих;

10.1.9. Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны ажлын тайланд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрмийг батлах.

³ 11.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэлбэршилтийн судалгаа хийж, эрдэс баялгийн нөөцийн үнэлгээ өгөх;

11.1.5 Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах

11.1.6 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээний талаар хяналт тавих

- 1.5. Дээрх чиг үүргийн дагуу ЭБЭХЯ “Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого 2021 он” үндэсний хөтөлбөрийг 2010 онд боловсруулж Засгийн газарт өргөн барьсан бөгөөд Засгийн газар 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн боловч Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлд танилцуулсны үндсэн дээр УИХ-д өргөн мэдүүлэх талаар тус зөвлөлийн Ажлын албанаас хүсэлт гаргасны дагуу уг асуудлыг 2011 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн ЗГ-1/148 дугаар албан бичгээр хүргүүлжээ. Гэвч Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлөөс дээрх бичгийн хариуг ирүүлээгүйгээс уг баримт бичиг өнөөг хүртэл батлагдаагүй байна.
- 1.6. ЭБЭХС-ын 2009 оны 81 дүгээр тушаалаар ЭБМЗ-ийн дүрэм, бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд уг дүрмийн 14⁴-т зааснаар мэргэшсэн шинжээчдийг томилон Оюу толгойн орд газрын хайгуулын ажлын тайланд 2 удаа дүн шинжилгээ хийлгэжээ.
- 1.7. Ашигт малтмалын тухай хуулийн (2006 оны) дагуу АМГ-ын Геологи судалгааны хэлтэс хайгуулын тусгай ажлын төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтийн явц, тайлагналд хяналт тавих чиг үүрэгтэй ч уг хууль батлагдахад Оюу толгойн орд газрын хувьд 2003 оноос ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байсан тул хайгуулын ажлын төлөвлөгөөг баталж, явцын хяналт хийх боломж бүрдээгүй бөгөөд 2007 онд зөвхөн хайгуулын ажлын тайлан, ЭБМЗ-ийн дүгнэлт, түүнийг нөөцөд бүртгэхийг даалгасан АМГТХЭГ-ын дарга, ЭБЭХС-ын тушаалын дагуу улсын нэгдсэн тоо бүртгэлд анх тусгасан байна.
- 1.8. 2009 онд нөөцийг дахин нэмэгдүүлж бүртгэхдээ мөн л хайгуулын ажлын тайланг хүлээн авсан бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу (2006 оны) хайгуулын ажлын төлөвлөгөө бус уулын ажлын төлөвлөгөөг АМГ-ын Уул уурхайн судалгааны хэлтсээр батлуулж, хяналт хийлгэх эрхтэй ч одоогоор батлагдсан нөөцөд хүдэр олборлолт эхлээгүй, харин уурхай барьж байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Босоо ам №1-ийн хувьд 1300 метрийн түвшинд хэвтээ малталт, нэвтрэлтийн ажил, Босоо ам №2-ын хувьд нэвтрэлтийн ажил хийгдэж байна.

Оюу толгойн орд газрын нөөцийг тогтоож, баталгаажуулсан талаар

- 1.9. Оюу толгойн зэс-алтны үндсэн орд газарт болон түүний ил аргаар ашиглах Өмнөд Оюугийн бүлэг ордод 1997-2005 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн нэгдсэн тайлан, орд ашиглах цогцолбор төлөвлөгөөнд ҮХС-ын (хуучин нэрээр) 2006 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 66 дугаар тушаалаар байгуулагдсан шинжээчдийн хэсэг 2006 оны 8 дугаар сарын 14-нд дүгнэлтээ гаргаж, 2007 оны 6 дугаар сарын 16-ны өдөр ҮХЯ, АМГТХЭГ(хуучин нэрээр)-ын ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн 16-01 дүгээр дүгнэлтээр нөөцийг анх дараах байдлаар тогтоожээ.

⁴ ЭБТЗ дүрмийн 14. “Зөвлөл ашигт малтмалын ордын хайгуулын ажлын тайлан, нөөцийн тооцоо, ТЭЗҮ-д хяналт хийж, шүүмж, дүгнэлт гаргах итгэмжлэгдсэн, мэргэшсэн шинжээч болон шинжээчдийн хэсэг, хуулийн этгээдийг зөвлөлийн нэрийн өмнөөс томилон ажиллуулна”

Хүснэгт 1. Өмнөд Оюугийн алт-зэсийн бүлэг ордын ил аргаар ашиглах нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт (2006 оны 1 дүгээр сарын байдлаар)

Нөөцийн ангилал	Хүдэр, сая.тонн	Си, %	Ау, г/т	Зэс, сая фунт	Зэс (сая.тонн)*	Алт, мян.унц	Алт (тонн)*
Баттай	127	0.58	0.93	1451	0.658	2833	88.1
Бодитой	803	0.48	0.27	7431	3.371	4768	148.3
Нийт	930	0.50	0.36	8882	4.029	7601	236.4

Тайлбар: *1 фунт = 453.6грамм, 1 унц = 31.1 грамм Эх сурвалж: ЭБЭХЯ⁵

1.10. Дээрх дүгнэлтийг үндэслэн АМГТХЭГ-ын даргын 2007 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 264 дүгээр тушаалаар Оюу толгойн зэс-алтны үндсэн ордын ил аргаар ашиглах Өмнөд Оюугийн орд (Хэсэг)-ын зэс, алтны хүдрийн баттай (А) нөөцийг хүдрээр 127.0 сая тонн, зэсээр 0.658 сая тонн, алтаар 88.1 тонн, бодитой (В) нөөцийг хүдрээр 803 сая тонн, зэсээр 3.371 сая тонн, алтаар 148.3 тонноор хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд анх бүртгэжээ.

1.11. ЭБЭХС-ын 2009 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 64 дүгээр тушаалаар Оюу толгойн зэс алтны ордын “Өмнөд Оюугийн бүлэг ордын нөөцийн тодотгол, Хюго Дамметын бүлэг орд болон Херуга ордын нөөцийн тайланд дүгнэлт гаргах” шинжээчдийн хэсгийг томилж, ЭБЭХЯ, АМГ-ын ЭБМЗ-ийн 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн 15 дугаар дүгнэлтээр нөөцийг нэмэгдүүлж дараах байдлаар тогтоожээ.

Хүснэгт 2. “Өмнөд Оюугийн бүлэг ордын нөөцийн тодотгол, Хюго Дамметын бүлэг орд болон Херуга ордын нөөцийн тайланд гаргасан дүгнэлт

Нөөцийн ангилал	Хүдэр, сая.тонн	Си, %	Ау, г/т	Алт (тонн)*	Зэс (сая.тонн)*	Молибден мян.тн	Мөнгө тн
Нийт үр ашигтай	2675.6	0.95	0.38	1028	25.4	81.6	6144
Нийт тодорхой нөхцөлд ашигтай	3775.9	0.52	0.21	810	19.7	75.5	5905
Нийт	6451.5	0.7	0.28	1838	45.0	157	12049

Нөөц нэмэгдсэн эсэх талаар

1.12. Оюу толгойн орд газрын нөөц нэмэгдсэн эсэхэд хийсэн шинжээчийн дүгнэлтээр Оюу толгойн уурхай одоогоор хүдрийн олборлолт хийх ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй, зөвхөн уулын үндсэн, нээх, бэлтгэл малталтуудыг хийж байгаа учир ЭБМЗ-ийн 2009 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдааны 15 дугаар дүгнэлтээр баталсан нөөцөд хөдөлгөөн ороогүй байна.

1.13. Нөгөө талаар Оюу толгойн бүлэг ордын талбайд одоогоор хайгуулын ажил үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд өмнө тогтоогдсон хүдрийн биетүүдийн хэлбэр, хил хязгаар, эрдэсжилтийн агуулгын тархац болон уул техникийн нөхцөлийг шалгаж баталгаажуулан ашиглалтын уулын ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулахад шаардлагатай нэмэлт мэдээллүүдийг тодотгох зорилгоор 2010, 2011 онуудад геологи хайгуулын өрөмдлөгийн ажлуудыг хийсэн байна.

1.14. Оюу толгойн бүлэг ордын талбайд хийгдэж буй хайгуул судалгааны ажлаар зарим хэсэгт хүдрийн биет илэрч байгаа ч (Херуга болон Баруун Өмнөд Оюутолгой ордын хооронд) түүнийг бүрэн судалж нөөц тооцоолох түвшинд хүрэхэд геологи хайгуулын ихээхэн ажил хийгдэх шаардлагатай бөгөөд нөөц

⁵ ЭБМЗ-ийн 2007 оны 16-ны өдрийн хуралдааны 16-01 дүгээр дүгнэлтийн хавсралт

тооцоолж баталгаажуулах нөхцөл бүрдээгүй байгаа тул Оюу толгой ордын хайгуулын ажлаар нөөц шинээр нэмэгдсэн гэх үндэслэл алга гэсэн шинжээчийн дүгнэлт гарсан байна.

Оюу толгойн орд газрын нөөцийн өөрчлөлтөд хэрхэн хяналт тавьж буй талаар

- 1.15. Монгол Улсын уул уурхайн салбарт ашигт малтмалын орд газрын нөөцийн өөрчлөлтөд хяналт тавих байгууллага, албан тушаалтны эрх үүргийг Ашигт малтмалын тухай хууль болон бусад хуулиар тогтоожээ.
- 1.16. Ашигт малтмалын тухай хуулийн (2006 оны) 11 дүгээр зүйлд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага:
 - Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэлбэршилтийн судалгаа хийж, эрдэс баялгийн нөөцийн үнэлгээ өгөх /11.1.2/
 - Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах /11.1.5/
 - Улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн эрдсийн хуримтлал бүхий талбайд тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах /11.1.13/
 - Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих /11.1.14/ чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.
- 1.17. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т “Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэх”-ээр хуульчилжээ.
- 1.18. Ашигт малтмалын орд газрын нөөцийг тогтоож, баталгаажуулах асуудлыг ЭБЭХС-ын 2009 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 81 дүгээр тушаалаар батлагдсан “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрэм”-ээр зохицуулж байна.
- 1.19. Тус дүрмийн “Нийтлэг үндэслэл”-ийн 1-д “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн бүх төрлийн ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн нөөцийн тооцоо, эдийн засгийн үнэлгээ бүхий тайлан, орд газрыг ашиглах буюу уул уурхайн үйлдвэрлэлийн техник, эдийн засгийн үндэслэл болон газрын тосны судалгаа, бусад үйл ажиллагаатай холбогдсон ажлын төсөл, төлөвлөгөө, үр дүн зэрэг асуудлыг хэлэлцэж, холбогдох хууль, дүрэм, судалгааны арга, аргачлалтай нийцэж буй эсэх талаар мэргэжлийн зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах эрхтэй” гэж заажээ.
- 1.20. Тус дүрмийн “Нийтлэг үндэслэл”-ийн 2.2-т Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнг хэлэлцэх Зөвлөлийн салбар хуралдаанаар:
 - Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журам
 - Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнд тогтоосон орд газрын нөөцийн тооцоо, нөөц тооцоолоход хэрэглэсэн жишгийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон үндэслэл зэрэг асуудлууд

- Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний тэнцэл, тухайн жилд нэмэгдсэн болон хасагдсан ашигт малтмалын нөөцийг улсын нөөцийн хөдөлгөөний тэнцэлд тусгах асуудал
- Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалтыг хэрэгжүүлэн тухайн хайгуул хийж нөөцийг нь тогтоосон орд газар, талбайд тэмдэглэл, дүгнэлт гаргах гэж ашигт малтмалын орд газрын нөөцийн асуудалтай холбоотой чиг үүргийг тодорхойлжээ.

1.21. Мөн ҮХС, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2007 оны 296/25 дугаар тушаалаар батлагдсан “Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хянан зөвшөөрөх журам”-ын дагуу ажлын төлөвлөгөө, тайлангаа журмын 4.2.7-д заасан маягт №2-оор, тухайн онд техникийн хилийн өөрчлөлтөөс нэмэгдсэн, хасагдсан, ашиглалтын явцад анх нөөц батлагдаагүйгээс хасагдсан, тооцоогоор нэмэгдсэн, хасагдсан нөөцийн мэдээллийг Эрчим хүч, геологи, уул уурхайн сайдын 1995 оны 258 дугаар тушаалаар батлагдсан ашигт малтмалын нөөцийн улсын баланс зохиох зааврын дагуу боловсруулан тухайн аж ахуйн нэгж АМГ болон мэргэжлийн хяналтын газарт ирүүлж байх ёстой. Уулын ажлын төлөвлөгөө болон тайлангийн хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хяналт тавих үүрэгтэй байна.

1.22. Үүнээс дүгнэхэд ашигт малтмалын орд газрын тогтоогдсон нөөцийн өөрчлөлтөд ЭБЭХЯ, түүний харьяа агентлаг, газрууд мэргэжлийн чиглэлийн хяналтыг хэрэгжүүлдэг боловч хуулийн дагуу хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар байна.

1.23. Оюу толгойн орд газрын нөөц тогтоосон байдалд хэн, хэрхэн хяналт тавьж байгааг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тодруулахад “Оюу толгой орд болон Монгол Улсын хэмжээнд ашигт малтмалын ордод хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБЭХЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, ашигт малтмалын нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, түүний хөдөлгөөний тайланг хүлээн авч байна” гэжээ.

Ерөнхий мэдээлэл

- 2.1. Таван толгойн нүүрсний ордын геологи хайгуулын ажил 1970-аад оноос эхэлсэн байна.
- 2.2. Улмаар 1984-1990 онуудад 10000 гаруй га талбайг (11956, 11943, 11952 дугаартай талбайнууд) хамарсан ордыг нээж 2-75м-ийн зузаантай нүүрсний 16 давхарга (0-ХУ давхаргууд) байгааг илрүүлээд 6,4 тэрбум тонн чулуун нүүрсний нөөц, үүнээс 1,8 тэрбум тонн нь коксжих нүүрс байгааг тогтоосон байна. Энэхүү тогтоосон нөөцийг тухайн үеийн салбарын яамдын шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталгаажуулсан байна.
- 2.3. Таван толгойн ордод улсын төсвийн хөрөнгөөр 1970 оноос хойш нийт 31 удаагийн геологи хайгуул-шинжилгээний ажил хийгдсэний 11 нь зөвхөн нүүрсний хайгуулд чиглэгдсэн байна.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон тухай

- 2.4. Таван толгойн нүүрсний орд бүхий талбайд 1900Х, 1901Х хайгуулын лицензүүдийг 1999 онд "Майн-Инфо" ЗБН-д, 1901Х-1 хайгуулын лицензийг 2002 онд "Энерго ресурс" ХХК-д тус тус олгосон байна. Эдгээр лицензийн талбайд өмнө нь хайгуул хийж нөөцийг тогтоож байжээ.
- 2.5. "Майн-Инфо" ХХК өөрийн нэр дээр байсан 1900Х, 1901Х лицензүүдээ 2000 онд "Энерго ресурс" ХХК-д шилжүүлсэн байна. Мөн Дарханхаан-Уул ХХК-ийн 5188Х, 5189Х, 5190Х, Энерго ресурс ХХК-ийн 1900Х, 1901Х, 1901Х-1 хайгуулын лицензүүд 2005 он гэхэд "Энержи ресурс" ХХК-д шилжсэн байна.
- 2.6. "Энержи ресурс" ХХК хайгуулын лицензүүдээ 2006 онд ашиглалтын лиценз болгосон байна.

	Хайгуулын лицензийн дугаар	Ашиглалтын лицензийн дугаар
Тавантолгой 1	1900Х	11943А
Тавантолгой	1901Х	11956А
Ухаахудаг	1901Х-1	11952А
Бортолгой	5188Х	11953А
Бор тээг 1	5189Х	11954А
Шар тээг	5190Х	11955А

- 2.7. УИХ-аас 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай /шинэчилсэн найруулга/ болон Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд 2006 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 30 дугаарт нийтлэгдсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн Хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь заалтад заасны дагуу нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа буюу 2006 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн байна.

- 2.8. “Энержи ресурс” ХХК-ийн эзэмшиж байсан ашигт малтмалын хайгуулын зургаан лицензийг ашигт малтмал ашиглах лиценз болгох тухай өргөдлийг АМГТХЭГ 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 12 цагт хүлээн авсан ба өргөдлийн дагуу АМГТХЭГ-ын Геологи, уул уурхайн кадастрын газрын даргын 2006 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 789, 2006 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 805 дугаар шийдвэрүүдээр зургаан ашигт малтмалын ашиглалтын лицензийг олгожээ.
- 2.9. Дээрх өргөдлийг шийдвэрлэх үед УИХ-аас 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай /шинэчилсэн найруулга/ болон Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд хүчин төгөлдөр болоогүй байсан тул ийнхүү хуучин хуулийг баримталсан байна.

Дагаж мөрдөх журмын тухай хуулийн талаар

- 2.10. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1-д 1997 оны хуулийн дагуу олгогдсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинээр батлагдсан хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 сарын хугацаанд уг хуульд заасан журмын дагуу шинэчлэн бүртгэхээр заажээ.
- 2.11. Энэхүү заалтын дагуу “Энержи ресурс” ХХК өөрийн эзэмшиж байсан ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 сарын дотор буюу 2007 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр шинэчлэн бүртгүүлжээ.
- 2.12. “Энержи ресурс” ХХК Ашигт малтмалын тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу шинэчилсэн бүртгэл хийлгэж, холбогдох нөхцөл шаардлагыг хангажээ.

Тусгай зөвшөөрлийг шилжүүлж авсан талаар

- 2.13. Засгийн газар Энержи ресурс ХХК-тай 2008 оны 3 дугаар сарын 21-ний өдөр "Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэх" тухай гэрээ байгуулж, 11952А дугаар ашиглалтын лицензийг өөрт нь үлдээж, 11943А, 11956А, 11953А, 11954А, 11955А дугаар лицензүүдийг Засгийн газраас нэр заасан хуулийн этгээдэд шилжүүлэхээр болжээ. Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь заалт болон холбогдох бусад хуулийн заалтыг үндэслэсэн байна.
- 2.14. Уг гэрээгээр Энержи ресурс ХХК-ийн 11952А дугаар лиценз бүхий Ухаа худгийн орд газрын талбайн булангийн цэгийн солбилцлуудыг шинэчлэн тогтоож 2962 га болгосон бөгөөд АМГТХЭГ-ын Геологи, уул уурхайн кадастрын газрын даргын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 817 дугаар шийдвэрээр өөрчлөн бүртгэжээ.
- 2.15. Энэ талбайг гэрээ хүчинтэй байх хугацаанд Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар нөөцөд авах, уг орд газарт төрийн хувь оролцоог тогтоохоор санал өргөн мэдүүлэх зэргээр ашиглалтын тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулахгүй буюу цуцлахгүй байх баталгааг Засгийн газар гаргасан бөгөөд гэрээний үүргээ зөрчвөл ашиглалтын 5 лицензийг Энержи ресурс ХХК-д буцаан олгохоор заажээ.

2.16. Дээрх гэрээгээр Ашигт малтмалын тухай хуулийн 5.4-т заасан төрийн эзэмшлийг тогтоож болох “50 хүртэл” гэсэн дээд хэмжээнээс илүү хувийг төрийн эзэмшилд шилжүүлж авчээ.

Эрдэнэс МГЛ ХХК болон Энержи ресурс ХХК-ийн хоорондын хамтын ажиллагааны талаар

2.17. Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4-т “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно” гэж заасны дагуу Засгийн газар ТӨХ-нд үүрэг болгосноор 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдөр тогтоол гаргажээ.

2.18. Энэ тогтоолоор Стратегийн ач холбогдол бүхий орд, улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордын ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулах, стратегийн ач холбогдол бүхий ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлж, төрд ногдох ашгийг төвлөрүүлэх, ашигт малтмалын үнэлгээ хийх, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн оролцоотой компануудын төрийн эзэмшлийн хувьцааг борлуулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн өмчит Эрдэнэс МГЛ ХХК байгуулжээ.

2.19. “Эрдэнэс МГЛ” ХХК нь “Энержи ресурс” компанитай Таван толгой орд газрыг ашиглах явцдаа “Хамтран ажиллах гэрээ”-г 2010 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр байгуулжээ. Энэ гэрээний хүрээнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт, зохион байгуулалт, маркшейдэр, геологийн ажлыг хийж гүйцэтгэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх болон шаардлагатай бусад асуудлаар харилцан туслалцаа үзүүлж хамтран ажиллахаар тохиролцсон байна.

2.20. Үүнээс гадна Энержи ресурс ХХК 2011 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр “Эрдэнэс МГЛ” ХХК-тай “Консерциумын гэрээ” байгуулах замаар Гашуун сухайтын хилийн боомт дахь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх гарц замыг 10 урсгалтай болгож, талбай, байгууламжийг өргөтгөх ажлыг хамтран хэрэгжүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн талаар

2.21. АМГТХЭГ болон ашигт малтмалын ордын 11952А дугаар тусгай зөвшөөрөл эзэмшигч “Энержи ресурс” ХХК-ийн хооронд байгуулсан ХАЗ-2008/21/155 дугаартай гэрээний дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь ЭХУУГЯ-ны ШУТЗ-ийн 1989 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 8 дугаар тогтоолоор олгогдсон тусгай зөвшөөрлийн талбайд улсын төсвөөс нийтдээ 4,304,875.00 төгрөгийн зардал гарсныг Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу 2008 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн байдлаар тооцож 1,188,100.00 ам.долларыг 5 жилийн хугацаанд дараахь байдлаар төлөхөөр тусгажээ.

Огноо	Дүн ам.доллараар	Дүн үсгээр
2009	288,100.00	Хоёр зуун наян найман мянга нэг зуу
2010	225,000.00	Хоёр зуун хорин таван мянга
2011	225,000.00	Хоёр зуун хорин таван мянга
2012	225,000.00	Хоёр зуун хорин таван мянга
2013	225,000.00	Хоёр зуун хорин таван мянга

2.22. Энержи ресурс ХХК гэрээний дагуу Голомт банк дахь АМГТХЭГ-ын 1141000903 дугаар дансанд 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 288,100.00 ам.доллар, 2010 оны 6 дугаар сарын 11-ний өдөр 900,000.00 ам.долларыг төлсөн байна.

Тусгай зөвшөөрлийн төлбөрийн талаар

2.23. "Энержи ресурс" ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн байдлыг дараахь хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №1

Эзэмшигч компани	Лицензийн дугаар	Он	Төлбөрийн дүн		Талбайн хэмжээ
			Ам.доллараар	Төгрөгөөр	
Энержи ресурс ХХК	11952 А	2006	5,055.00		1011 га
Энержи ресурс ХХК	11952 А	2007	5,055.00		1011 га
Энержи ресурс ХХК	11952 А	2008	14,810.00		2960 га
Энержи ресурс ХХК	11952 А	2009		21,352,762.00	2960 га
Энержи ресурс ХХК	11952 А	2010		20,296,477.80	2960 га
Энержи ресурс ХХК	11952 А	2011		18,625,323.12	2960 га

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Нэг. Оюу толгойн орд газрын нөөцийн талаар

- 1.1. Оюу толгойн зэс-алтны орд газрын нөөцийг 2007, 2009 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэн ашигт малтмалын нөөцийн 2007, 2009 оны улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна.
- 1.2. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2009 оны 15-01 дүгээр дүгнэлт, ЭБЭХС-ын 2009 оны 167 дугаар тушаалыг үндэслэн Оюу толгойн бүлэг ордын геологийн нийт нөөцийг хүдрээр 6451.5 сая тонн, зэсээр 45.0 сая тонн, алтаар 1838 тонн, молибден 157 мянган тонн, мөнгө 12049 тонн гэж бүртгэжээ.
- 1.3. Оюу толгойн бүлэг ордын талбайд хайгуулын ажил одоо ч үргэлжлэн явагдаж, хайгуул судалгааны ажлаар зарим хэсэгт хүдрийн биет илэрч байгаа ч түүнийг бүрэн судалж нөөц тооцоолох түвшинд хүрэхэд геологи хайгуулын ихээхэн ажил хийгдэх шаардлагатай бөгөөд нөөц тооцоолж баталгаажуулах нөхцөл бүрдээгүй байгаа тул Оюу толгой ордын хайгуулын ажлаар нөөц шинээр нэмэгдсэн гэж үзэх боломжгүй байна.

Хоёр. Энержи ресурс ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талаар

- 2.1. Энержи ресурс ХХК-ийн ашигт малтмалын хайгуулын лицензээ ашиглалтын лиценз болгохоор 2006 оны 7 дугаар сарын 8-нд гаргасан өргөдлийг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.
- 2.2. Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь заалт болон холбогдох бусад хуулийг үндэслэн "Энержи ресурс" ХХК-тай 2008 оны 3 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулж тус компанийн 6 лицензийн 1-ийг нь өөрт нь үлдээж, 5-ыг нь шилжүүлж авсан байна.
- 2.3. Хэрэв Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.5 дахь заалтыг баримтлах, мөн Засгийн газар болон Энержи ресурс ХХК-ийн хоорондын гэрээний үүрэг зөрчигдөх тохиолдолд Энержи ресурс ХХК-д ашиглалтын 5 лицензийг нь буцаан олгох, аль эсвэл төрийн оролцооны хувь хэмжээг 50 хүртэл хувиар бууруулах үр дагавар үүсэхээр байна.

Холбогдох байгууллагын санал

Засгийн
газрын хэрэг
эрхлэх газар



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 12 он 04 дугаар
сарын 27 ны өдөр

Дугаар ХТ/365

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас "Оюутолгойн орд газрын нөөцийг тогтоож баталгаажуулсан болон Энержи ресурс ХХК-д нүүрсний орд ашиглах талбай, тусгай зөвшөөрлийг зохицуулан олгосон байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар танилцаад дараахь тайлбар, саналыг өгч байна:

Тайлбар
1-ийг үзнэ үү

Тайлангийн 1.5-д "Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого 2021 он" үндэсний хөтөлбөрийг 2010 онд Засгийн газарт өргөн барьсан ч батлагдаагүй" гэж дурдсан байна. "Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн боловч Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлд танилцуулсны үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх талаар тус зөвлөлийн Ажлын албанаас хүсэлт гаргасны дагуу уг асуудлыг 2011 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн ЗГ-1/48 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Гэвч Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлөөс эрдэс баялаг, эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн талаар өнөөг хүртэл хариу ирүүлээгүй байна.

Тайлбар
2-ыг үзнэ үү

Тайлангийн 1.16-д "Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж өөрчлөх.

Тайлбар
3-ыг үзнэ үү

Тайлангийн дүгнэлтийн хэсгийн 1.1-ийг "Оюу толгойн зэс-алтны орд газрын нөөцийг 2009 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын 2009 оны нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна" гэж найруулах.

Тайлбар
4-ийг үзнэ үү

Тайлангийн дүгнэлтийн хэсгийн 1.2-т "... зэсээр 45.0 сая тонн" гэсний дараа "үүнээс 31.0 сая тонн нь эдийн засгийн үр ашигтай" гэж нэмэх.

Аудитын тайланд архивын холбогдох материалыг хавсаргаж Улсын Их Хуралд хүргүүлэх нь зүйтэй байна.



Тэргүүн дэд дарга

Ш.СОЛОНГО



МОНГОЛ УЛСЫН
ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ
САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтай дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (076-11) 31-13-81

2012.02.13 № 9/473
танай 01/н -ны № 162 -т

Санал өгөх тухай

Танай 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 162 дугаар албан тоотоор ирүүлсэн "Оюутолгойн орд газрын нөөцийг тогтоож баталгаажуулсан болон "Энержи ресурс"ХХК-д нүүрсний орд ашиглах талбай, тусгай зөвшөөрөл олгосон байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналтай байна. Үүнд:

1.Оюу толгойн орд газрын нөөцийг баталгаажуулсан талаар:

1.1.Тайлангийн 1.2-т "Уг орд нь хүрэл зэвсгийн үеэс мэдэгдэж байсан ..., уг ордыг Бор-Овооны зэсийн илрэл гэж, ... энэ ордод хайгуулын ажил хийх эхлэл тавигджээ" гэх мэт хэллэгүүдэд анхлан ашигт малтмалын эрдэсжсэн цэг, илрэл байдлаар судлагдаж байгаад цаашид хайгуулын ажлын үр дүнд "ашигт малтмалын орд" гэсэн ойлголтод хүрсэн гэдгийг Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.8-д заасны дагуу ойлгож тэмдэглэх,

1.2.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2010 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 24-01 дүгээр дүгнэлт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 71 дүгээр тушаалаар Оюу толгойн бүлэг ордыг ашиглах уурхай, баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан. Энэхүү шийдвэрийн хүрээнд өмнө нь бүртгэгдсэн 45,0 сая тн, зэсийн 31,0 сая тн, буюу 68,9 хувь нь үр ашигтай нөөцөд шилжиж, тодорхой нөхцөлд ашигтай зэсийн нөөц 13.96 сая тн болсон байна. /дараах хүснэгт/

Оюу толгойн бүрэн ордын нөөц

Нөөцийн ангилал	Хүдэр сая тн.	Металлын агуулга			Хүдэр дэх металл	
		Зэс хувь	Алт г/тн	Мөнгө г/тн	Зэс мян.тн.	Алт, тн.
Үр ашигтай нийт	3381	0,92	0,34	2,26	31068,0	1158,2
Тодорхой нөхцөлд ашигтай	3069	0,45	0,22	1,44	13964,0	680

08000 4

2.Монгол Улсын Засгийн газраас “Энержи ресурс” ХХК-тай 2008 оны 03 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай гэрээ”-г Монгол Улсын Үндсэн хуулийн 16.3, Иргэний хууль дахь гэрээ, хэлцэлтэй холбоотой заалтын дагуу байгуулсан байна.

2.1.Уг гэрээгээр тус компанийн хууль ёсны эзэмшилд байсан ашигт малтмал ашиглах 6 тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь орд нь хэмжээ болон нийгэм, эдийн засгийн ач холбогдлын хувьд Монгол Улсад онцгой ач холбогдолтой тул Засгийн газраас Үндсэн хуулийн 13.3-т заасан “Нийгмийн зайлшгүй хэрэгцээ” үүссэн байна гэж үзээд тусгай зөвшөөрлүүдийг төрийн эзэмшилд дайчлан авахаар ажилласан байна.

2.2.Энэхүү гэрээгээр Ашигт малтмалын тухай хуулийн 5.4-т заасан төрийн эзэмшлийг тогтоож болох “50 хүртэл” гэсэн дээд хэмжээнээс хавьгүй илүү хувийг төрийн бүрэн эзэмшилд шилжүүлэн авч чадсан байна. Ингэснээр Төр Таван толгойн нүүрсний ордыг дангаар хөгжүүлж, түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдсэн ба энэ нь Монгол Улсын эрх ашигт бүрэн нийцсэн, хамгийн ашигтай хувилбар болж чадсан гэж үзэж байна.

2.3.Тайлангийн төслийн 2.15 болон дүгнэлтийн 2.2 дахь заалтын хувьд тайлбарлахад тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай гэрээ нь Ашигт малтмалын тухай хуулийн 5.3, 5.4 дэх заалтад заасан “орд ашиглах гэрээ” биш тул Засгийн газрын хувьд төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоолгох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлага тухайн үед үүсээгүй байна.

Тайлбар
5-ыг үзнэ үү

Тайлбар
6-г үзнэ үү

САЙД  Д.ЗОРИГТ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 25-36-28, Факс: 31-03-70
E-mail: info@mrpm.gov.mn

2012.04.03 № 1-774

танай 2012.04.01 -ны № 162 -Т

Танай байгууллагаас ирүүлсэн "Оюутолгойн орд газрын нөөцийг тогтоож баталгаажуулсан болон Энержи ресурс ХХК-д нүүрсний орд ашиглах талбай, тусгай зөвшөөрөл олгосон байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Танай байгууллагын гаргасан УАГ-ГАГ/2012/ЭА-01 тоот Аудитын тайлангийн агуулга, хийж гүйцэтгэсэн шалгалтын үр дүнтэй холбоотойгоор тус газраас гаргах санал байхгүй байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.АРИУНБАЯР

10 01341



**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ Б. БАТБАЯР ТАНАА**

Үндэсний аудитын газраас 2012 оны 02-р сарын 01-ний 162 тоот албан бичгээр ирүүлсэн аудитын дүгнэлтийг хүлээж авлаа. Оюу толгойн ордын нөөцийг тогтоож баталгаажуулсан байдалд хийсэн аудитын дүгнэлттэй зарчмын хувьд санал нийтж байна.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙЛОГЧ БӨГӨӨД
ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ



КАМЕРОН МАКРЭЙ

Oyu Tolgoi LLC
Улаанбаатар-14240
Сүхбаатар дүүрэг
Хангайн замын 4000-15
"Амьтан үйлдвэр"
Утас: 076 111 221800
Факс: 076 111 221800
E-mail: oyu@ot.mn
Web: www.ot.mn

Oyu Tolgoi LLC
Morris Tower
Chinggis Avenue 15
Sukhbaatar District
Ulaanbaatar 14200, Mongolia
Tel: 076 111 221800
Fax: 076 111 221800
E-mail: oyu@ot.mn
Web: www.ot.mn

01990

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Б.БАТБАЯР ТАНАА

Санал өгөх тухай

Таны 2012 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 162 тоот албан бичгээр ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцаад дараахь тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. “Ашигт малтмалын тухай” хуулийн 5.4-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Сангийн яам манай компанитай 2007 онд хэлэлцээр хийсэн бөгөөд уг хэлэлцээрээр стратегийн орд газарт хамаарах зургаан тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь ордыг төртэй хамтран ашиглаж төрд хувьцааны 86 хувийг эзэмшүүлэх тохиролцоонд хүрч байсан билээ.

Гэсэн хэдий ч Засгийн газрын зүгээс Үндсэн хуулийн 16.3-д заасан нөхцөл үүссэн тул тусгай зөвшөөрлүүдийг бүрэн дайчлан авах, ордыг хамтарч ашиглахгүй байх байр суурийг баримтлан 2008 онд дахин хэлэлцээр хийж хэлэлцээрийн төгсгөлд “тусгай зөвшөөрөл шилжүүлэх, нөхөн олговор олгох” асуудлыг нэг гэрээгээр хамтад нь шийдвэрлэхээр тохиролцоонд хүрч 2008 оны 08 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулсан болно.

Засгийн газрын зүгээс төрд таван тусгай зөвшөөрөл шилжүүлснийг “Ашигт малтмалын тухай” хуулийн 5.4-т заасан шаардлагыг бүрэн биелүүлсэн гэж үзэн тус компанид шилжүүлсэн нэг тусгай зөвшөөрлийн тухайд төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоохгүй байх, уг тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулахгүй байх, цуцлахгүй байх талаар баталгааг өгч энэ талаар гэрээнд тусгасан болно.

Тус гэрээгээр Ашигт малтмалын тухай хуулийн 5.4-т заасан төрийн эзэмшлийг тогтоож болох “50 хүртэл” гэсэн дээд хэмжээнээс хавьгүй илүү хувийг төрийн эзэмшилд шилжүүлсэн болно. Тус компанийн зүгээс үндэсний аж ахуйн нэгж болохын хувьд Монгол Улсын нийтлэг эрх ашиг, нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хүндэтгэн Засгийн газрын саналыг хүлээн авсан ба гэрээг хуулийн дагуу байгуулсан гэж үзэж байна.

2008 оны гэрээний хууль зүйн үндэслэл нь Үндсэн хуулийн 16.3 дахь заалт болон холбогдох бусад хуулийн заалт байсныг тайлангийн 2.14 дахь заалтад тусгаж “Засгийн газар Энержи ресурс ХХК-ийн орд газар ашиглах лицензийг шилжүүлж авахдаа Үндсэн хуулийн 16.3 дахь заалт болон холбогдох бусад хуулийн заалтыг үндэслэсэн байна” гэсэн томъёоллыг анхаарч үзэхийг хүсч байна.

Тайлбар
7-г үзнэ үү

Харин тайлангийн дүгнэлт хэсгийн 2.2 дахь заалтын хувьд тухайн үед төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоолгох талаар Улсын Их Хуралд санал өргөн мэдүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлага Засгийн газарт байсан эсэхийг Засгийн газар, түүний эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас тодруулах нь зүйтэй болов уу.

2.Тайлангийн 2.5 дахь заалтыг “Эдгээр лицензийн талбайд өмнө нь хайгуул хийж нөөцийг нь тогтоож байсан байна” гэж найруулах саналтай байна.

Хүндэтгэсэн,

Г.БАТЦЭНГЭЛ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Үндэсний аудитын газрын тайлбар

Тайлбар 1

Саналыг хүлээн авч тайлангийн 1.5-д найруулгын өөрчлөлт хийлээ.

Тайлбар 2

Саналыг хүлээн авч тайлангийн 1.16-д “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тусгалаа.

Тайлбар 3

Саналыг хүлээн авч тайлангийн дүгнэлт хэсгийн 1.1-д найруулгын өөрчлөлт хийлээ.

Тайлбар 4

ЭБМЗ-ийн 2010 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 24-01 дүгээр дүгнэлтээр Оюутолгой ордын ТЭЗҮ-ийг хүлээн авч, түүнд үндэслэн ЭБЭХС-ын 2010 оны 71 дүгээр тушаалаар АМГ ТЭЗҮ-ийг нэгдсэн бүртгэлд авсан бөгөөд олборлолтын үйл ажиллагаа хийгдэж уулын ажлын тайлангаа ирүүлсний дараагаар ашигт малтмалын ордын нөөцийн хөдөлгөөн хийгдэх ёстой байна.

Тайлбар 5

Саналыг хүлээн авч тайлангийн 2.16-д тусгав.

Тайлбар 6

Саналыг хүлээн авч тайлангийн дүгнэлт хэсгийн 2.2-т тусгав.

Тайлбар 7

Саналыг хүлээн авч тайлангийн 2.4-т тусгав.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2012 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг."Оюу толгойн орд газрын нөөцийг тогтоож баталгаажуулсан болон "Энержи ресурс" ХХК-д нүүрсний орд ашиглах талбай, тусгай зөвшөөрөл олгосон байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Ашигт малтмалын газар, "Оюу толгой" ХХК, "Энержи ресурс" ХХК-д тус тус хүргүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070084